## 3.5 ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Улаанбаатар хот

| Д/Д | СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ | САНХҮҮЖИЛТ /САЯ ТӨГРӨГ/ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | СУУРЬ ТҮВШИН | 2025 ОНД ХҮРЭХ ЗОРИЛТОТ ТҮВШИН | ХУГАЦАА /I-IV УЛИРАЛ/ | БИЕЛЭЛТ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 1. ХОРТ ХАВДРЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ** | | | | | | | |
| 1.1 | Хорт хавдрын эрт илрүүлгийн зааврыг батлуулах, хэрэгжилтийг мэргэжил арга зүйгээр ханган хэрэгжүүлнэ. | 5,0 | – Эрүүл мэндийн сайдын тушаал<br>– Эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь | 2012 оноос умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг хэрэгжсэн. УХХХ хамрагдалтын хувь 38% | – Зонхилон тохиолдох 7 байрлалын хорт хавдрын эрт илрүүлгийн хөтөлбөр ЭМС-ын тушаалаар батлагдсан байна.<br>– Илрүүлгийн хамрагдалтын хувь 40% ба түүнээс доошгүй | I-IV улирал | 1. Хавдрын эсрэг үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд зонхилон тохиолдох 7 төрлийн хорт хавдрын эрт илрүүлгийн заавар боловсруулах, нэгтгэж ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>2. Улсын хэмжээнд 2025 оны эхний 10 сарын байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан эрт илрүүлэгт зорилтот насны нийт 69356 (28.1%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 4.4 хувь нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй. Үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн 9 тохиолдол бүртгэгдсэн байна.<br>3. Хөхний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 484279 эмэгтэй хамрагдсанаас 854 (0.2%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг буюу хорт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хавдрын шинэ өвчлөлийн 1 тохиолдол<br>бүртгэгдсэн байна.<br>4. Хорт хавдрын эрт илрүүлгийн бүртгэлд хэрэглэх анхан шатны маягт, хорт хавдрын бүртгэлийн АМ-5, хяналтын хуудсыг дахин шинэчилэн боловсруулж ХСҮТ Ерөнхий захирлын 01/1450 албан тоотоор ЭМХТ-д хүргүүлсэн.<br>5. Олон улсын хорт хавдрын бүртгэлийн холбоо (IACR) 2024 оны умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн тоо мэдээ илгээсэн.<br>6. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албатай хамтран Монгол улсад 10 сарыг дархлаажуулалтыг дэмжих сарын аяны хүрээнд дараах сургалтуудад “Хорт хавдрын өнөөгийн нөхцөл байдал-Умайн хүзүүний хорт хавдар” сэдвээр ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын алба, НЭМҮТөвтэй хамтран оролцлоо.<br>- Нийслэлийн 6 дүүргийн ЕБС-ын багш, нийгмийн ажилтан, сайн дурын ажилтан нарт<br>- Замын-Үүдийн нэгдсэн эмнэлэг, Дорноговь аймгийн НЭ, Говь-Сүмбэр аймгийн НЭ эмч, мэргэжилтэнүүд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Нийслэлийн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвд хамтарсан сургалтыг хийлээ.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 1.2 | 2015 оны А/351 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ. | - | – Шинэчлэн батлуулсан ЭМС-ын тушаал<br>– Тушаалын хэрэгжилтийн хувь | ЭМС-ын 2015 оны А/351 дүгээр тушаалыг батлуулан, хэрэгжүүлж байсан. | – Шинэчлэн батлуулсан ЭМС-ын тушаал-1<br>– Тушаалын хэрэгжилтийн хувь -70%-иас доошгүй | I-IV улирал | Эрүүл мэндийн сайдын тушаалаар томилогдсон Ажлын хэсэг ажиллаж, 2015 оны А/351 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулж, ЭМЯ-д хүргүүлсэн. Тушаалын төсөл ЭМЯ-ны удирдлагын зөвлөлд танилцуулагдсан.<br><br>**Гүйцэтгэл: 90%** |
| 1.3 | Даван туулагчийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. | 50,0 | Даван туулагчийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Даван туулагчийн хөтөлбөрийн эхний хувилбарыг боловсруулан, хэлэлцүүлж байна. | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь - 80 ба түүнээс доошгүй | IV улирал | Хавдрын даван туулагчийн хөтөлбөр нь "Үндэсний хэмжээнд хавдрыг даван туулагч сайн дурын идэвхитнүүдийг бэлтгэх, тасралтгүй чадавхижуулах, тэдний хүрч очих ажлыг дэмжих цогц хөтөлбөрийг хэрэгжүүлснээр байнгын үйл ажиллагаа бүхий хавдрын туулагчдын сүлжээг бий болгох" зорилготой хөтөлбөр боловсруулсан. Энэхүү хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 15 ажлыг 2025-2027 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Уг хөтөлбөрийг ЭМС-ын тушаалаар батлан үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлсэний дагуу, ЭМС-ын тушаалын төсөл боловсруулан ЭМЯ-д 2025 оны 6-р сард илгээсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Гүйцэтгэл: 70%** |
| 1.4 | Мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | 10,0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт- 91% байсан. | Төлөвлөгөөний хэрэгжилт 95%-иас доошгүй байна | I-IV улирал | ХСҮТ-ийн Олон нийтэд зориулсан сургалт мэдээлэл сурталчилгааны 2025 оны ажлын төлөвлөгөөг сургалт ба мэдээлэл сурталчилгаа гэсэн 2 бүлгийн хүрээнд нийт 9 төрлийн ажил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, төлөвлөгөөний хэрэгжилт 100%.<br><br>**Сургалт:**<br><br>1. **СВСТ – энэрэх сэтгэлийг хөгжүүлэх 8 модуль сургалт:** Ажилтнуудын харилцаа, сэтгэлзүйн ур чадварыг дэмжих зорилгоор зохион байгуулж, нийт 387 ажилтан хамрагдсан.<br>2. **Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалт:** Тасаг, албадын төлөөлөл болох 30 ажилтан сургалтад хамрагдаж, ёс зүйн чадавх бэхжсэн.<br>3. **Олон нийтэд сургалт мэдээлэл түгээх арга зүйн сургалт**: Сувилахуйн албатай хамтран 2 удаа зохион байгуулж, 30 ажилтны чадварыг нэмэгдүүлсэн.<br>4. **Хавдрын сэтгэл зүйн сургалт (аймаг, дүүрэг, төв эмнэлгүүдэд):** 90 гаруй сувилагчид зориулж зохион байгуулсан.<br>5. **Өвчтөнтэй харилцах эмпати сайжруулах сургалт**: Сувилагч |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нарт зориулан 2025 оны 4-р сард хэрэгжүүлсэн.<br>6. **Өвдөлт, таагүй мэдрэмжийг даван туулах сэтгэлзүйн сургалт**: Халдварын хяналтын албанд зориулж зохион байгуулсан.<br>7. **Хакоми урлаг заслын сургалт (оюутнуудын хамтарсан төсөл)**: 2025 оны 6-р сард зохион байгуулсан.<br>8. **Hiking therapy — эмнэлгийн ажилчдын алхалтын бүлэг:** Жилдээ 12 удаа тогтмол зохион байгуулсан.<br>9. **Дархлаажуулалтын чиглэлийн сургалтууд**: HPV болон элэгний B вирусийн вакцины талаар 7 удаа, нийт 500 гаруй хүнийг хамруулсан.<br><br>**Мэдээлэл, сурталчилгаа**:<br><br>1. **Хавдрын урьдчилан сэргийлэлт ба эрт илрүүлгийн 3 төрлийн видео шторк:** Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл, ХПВ, элэгний B вирусийн талаарх шторкуудыг бүтээж, олон нийтийн сувгуудаар түгээсэн.<br>2. **“Сувилагчийн нэг өдөр”, “Эмнэлгийн физикчийн нэг өдөр” баримтат кино:** Мэргэжилтний ажлын онцлогийг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | олон нийтэд сурталчлан түгээсэн.<br>3. **Эрүүл мэндийн боловсролын 15 төрлийн постер контент:** Төвийн пэйж, веб сайт, танхимын дэлгэцээр тогтмол түгээсэн.<br>4. **Сэтгүүлчдийн бүтээлийн уралдаан ба нөлөөллийн уулзалт:** Хавдрын урьдчилан сэргийлэлт, шинэ технологийг олон нийтэд зөвөөр хүргэх зорилготойгоор зохион байгуулсан.<br>5. **LIVE зөвлөгөө, цахим мэдээлэл түгээх ажил:** НЭМҮТ-тэй хамтран 4 удаагийн лайв хийсэн.<br>6. **Хавдрын эсрэг кампанит ажлууд:** “Улаанбаатар марафон 2025”, Хавдрын эсрэг дэлхийн өдөр зэрэг хүрээнд олон нийтэд зөвлөгөө, мэдээлэл өгч 100+ иргэнд хүрсэн.<br>7. **Товхимол, гарын авлага боловсруулалт:** Хоол зүй, сэтгэл зүй, нийгмийн дэмжлэг зэрэг 3 төрлийн товхимол хэвлэгдэн ашиглалтад орсон.<br>8. **Хэвлэл мэдээллийн тогтмол хамтын ажиллагаа:** МҮОНТ, Eagle, UBS, ETV зэрэг олон телевизээр дамжуулан мэдээлэл тогтмол хүргэж, ХСҮТ-ийн пэйжийн дагагч 75,000 хүрсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 9. **Хавдрын эсрэг хөгжим эмчилгээний өдөр:** 20 гаруй урлагийн байгууллагын 40 гаруй төлөөлөлтэй уулзалт хийж, нөлөөллийн ажлын хүрээг өргөтгөсөн.<br><br>***Хавсралт 1: Олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны тайлан-2025***<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 1.5 | **<u>БСТ-4.9.4</u>**<br>Орон нутагт эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхийг нэмэгдүүлнэ. | 3,0 | – Зохион байгуулсан сургалтын тоо<br>– Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо<br>– Аймаг, дүүргийн эмнэлэгт хийгдсэн мэс заслын тоо | 2024 онд эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын эмч Өмнөговь, Сүхбаатар аймагт 3-5 хоног сэлгэн ажиллаж, 10 эмчийг ажлын байранд дагалдуулан сургаж, эмэгтэйчүүдийн хавдрын 5 мэс заслыг тухайн аймгийн эмч нартай хамтран хийсэн. | – 3-4 аймагт сургалт зохион байгуулсан байна.<br>– 30-аас цөөнгүй эмч, мэргэжилтнүүд хамрагдсан байна.<br>– Аймаг, дүүргийн эмнэлэгт 10-аас цөөнгүй хавдрын мэс заслыг хамтран хийсэн байна. | I-IV улирал | Увс, Өмнөговь, Дорноговь, Архангай аймгуудад эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын эмч нарын баг (8 эмч) сэлгэн ажилласан.<br>Дээрх ажлын хүрээнд:<br>• Умайн хүзүүний хорт хавдрын эрт оношилгоо, эмчилгээ сэдэвт 2 багц цагийн сургалт болон ажлын байранд дагалдан сургалт зохион байгуулсан.<br>• Сургалтад 130 эмч, мэргэжилтэн хамрагдсан.<br>• Ажиллах хугацаанд орон нутгийн эмч нартай хамтран нийт 25 мэс засал, 526 хүнд үзлэг хийсэн.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| **ЗОРИЛТ 2. ХОРТ ХАВДРЫН ЛАВЛАГАА ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ** | | | | | | | |
| **2.1 Хорт хавдрын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | ISO-15189 стандартыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэнэ | 20,0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - Тус төвийн Эмгэг судлал болон Лабораторийн тасагт ISO-15189 стандартыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлсэн<br>- Уг стандартын баталгаажилт хийгдээгүй | ISO 15189 стандартын магадлан итгэмжлэл авахаар Стандартчилал хэмжилзүйн үндэсний төвд хүсэлт гаргасан байна. | I-IV улирал | ISO15189 стандартын магадлан итгэмжлэл авах ажлын бэлтгэл ажлын төлөвлөгөөг 100% хэрэгжүүлэн ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>– Тоног төхөөрөмжийн бүртгэл, пипетка, термометрийн баталгаажуулалт хийгдсэн.<br>– Ажлын заавар, Тоног тоног төхөөрөмжийн заавар, Стандарт ажиллагааны заавар боловсруулсан<br>Дараах 4 Стандарт ажлын зааврыг шинэчлэн боловсрууллаа. Үүнд:<br>1. Биохимийн стандарт ажиллагааны заавар-3<br>2. Иммунологийн стандарт ажиллагааны заавар -20<br>3. Бактериологийн стандарт ажиллагааны заавар -11,<br>4. Тоног тоног төхөөрөмжийн -4<br>5. Клиник гематологийн стандарт үйл ажиллагааны заавар-12, ТАЗ-3<br>Стандартчилал хэмжилзүйн үндэсний төвд ISO-15189 стандартын магадлан итгэмжлэх авах хүсэлтийг бэлтгэсэн. Лабораторийн их засварын ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж дуусахаар илгээхэд бэлтгэсэн.<br><br>**Гүйцэтгэл: 85%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | Стандарт үйл ажиллагааны заавар (СҮАЗ)-ыг шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллана. | – | – Шинэчлэгдсэн СҮАЗ-ын эзлэх хувь<br>– СҮАЗ-ын хэрэгжилтийн хувь | – Тасаг албадын СҮАЗ боловсруулагдаад 3 жил болсон.<br>– Шинэчлэх шаардлагатай байна. | – Тасаг албадын 80-аас доошгүй хувь СҮАЗ-аа шинэчлэн боловсруулсан байна.<br>– СҮАЗ-ыг 80 ба түүнээс дээш хувь хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | 1. Хавдар судлалын үндэсний төвд “Чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоо”-г хэрэгжүүлэхийн тулд тасаг, албаны үйл ажиллагаа, ажил үүргийн хуваарийг нарийвчлан заасан стандартыг боловсруулж, хэрэгжүүлсэнээр стандарт үйл ажиллагаа бүхий манлайлах эрүүл мэндийн байгууллага болох зорилготойгоор бүх алба тасагт удирдамж боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлаар батлуулан тараасан.<br>2. 2025 оны 05 оны 01-нээс 2025 оны 08 дугаар сарын 31-ний хооронд шинэчлэх үйл ажиллагаанууд төлөвлөгөөний дагуу хийгдэж дууссан.<br>3. 2025 онд байгууллагын бүтэц шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Ерөнхий захирлын А/01 дугаар тушаалын дагуу уг ажлыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдон түр хойшлуулаад байна.<br><br>**Гүйцэтгэл: 90%** |
| 2.1.3 | Эрсдэлийн удирдлагын тогтолцооны чиглэлээр сургалт зохион байгуулна. | – | – Батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө | 2024 онд Эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалтад нийт | – Батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу нийт | I-IV улирал | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны Эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежер сургалтын төлөвлөгөө боловсруулан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | – Сургалтад хамрагдсан эмч, сувилагч, ажилчдын эзлэх хувь | тасаг албадын эмч, эмнэлгийн ажиллагсадын 80% хамрагдсан. | ажиллагсадын 85-аас дээш хувийг хамруулан сургалт зохион байгуулсан байна. | | 2025 оны 04 дүгээр сарын 01-нээс 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хооронд 31 алба, тасгийн нийт 218 ажилтанд “Эрсдэлийн менежментийн тогтолцоо” сэдвээр сургалт орсон. Мөн шинээр ажилд орж буй 118 ажилчдад 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр “Эрсдэлийн менежментийн тогтолцоо” сэдэвт сургалт орсон. Нийт ажилчдын хамрагдалтын хувь 91% байна.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 2.1.4 | Толгой хүзүүний хавдрын онцлогт тохирсон эмчилгээний хоолны нэр төрлийг нэмэгдүүлж, үйлчилнэ. | 10,0 | – Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний хоолны нэр төрөл<br>– Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь | Эмнэлзүйн хоол эмчилгээний зааврын дагуу 50 гаруй технологийн карт боловсруулан мөрдөж байна. | – Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний хоолны 10-аас доошгүй нэр төрөл<br>– Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь -90% | III-IV улирал | Толгой хүзүүний хавдартай үйлчлүүлэгчдийн онцлогт тохирсон дараах 8 нэр төрлийн хоолны жорыг шинээр боловсруулж үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн. Үүнд:<br><br>1. Амтат төмс,брокколины зутан шөл<br>2. Мах, сэвэг зарамтай зутан шөл<br>3. Лууван, шар будааны зутан шөл<br>4. Ногоон хулуу, мах, төмстэй зутан<br>5. Цэцэгт байцаа, хүүхдийн будааны зутан шөл<br>6. Шингэн бантан<br>7. Брокколи, ногоон хулууны зутан шөл<br>8. Сэвэг зарам, төмсний зутан шөл<br><br>Толгой хүзүү нөхөн сэргээх мэс заслын тасагт хэвтэн эмчилгээ хийлгэсэн 40 үйлчлүүлэгчдээс шинээр нэмэгдсэн дээрх 8 төрлийн зутан шөлний амт чанар, шим |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тэжээлийг үнэлсэн сэтгэл ханамжийн судалгааг авсан. Судалгааны үр дүн:<br>1. Амт чанарын үнэлгээ - 95.6%<br>2. Тэжээллэг байдлын үнэлгээ – 93.7%<br>3. Ерөнхий сэтгэл ханамж – 96.7%<br><br>Энэ нь шинээр нэмэгдсэн 8 төрлийн зутан шөл өвчтөнүүдийн хэрэгцээнд нийцэж, амт, чанар, тэжээллэг байдлаараа өндөр үнэлгээ авсныг харуулж байна.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 2.1.5 | Байгууллагын засварын ажлын төлөвлөгөөг батлуулан, засвар үйлчилгээг хийж гүйцэтгэнэ. | 5700,0 | Засварын ажлын гүйцэтгэлийн хувь | 2024 онд тасгийн засвар ажлын зураг төсөл хийгдсэн. | – Засварын ажлын гүйцэтгэлийн хувь-80% ба түүнээс дээш | I-IV улирал | – ХСҮТ болон Л ХОЁР ХХК нь 2024 оны 6-р сарын 7-ны өдөр №НОННХСҮТ202401015 тоот гэрээг байгуулж, 2024 оны 12 сард байгууллагын засварын ажлыг эхлүүлсэн. 2025 оны байдлаар барилгын хана, дээвэр, сантехникийн ажлыг оролцуулан, барилга угсралтын ажил 80%-тай явагдаж байна.<br>– “ХСҮТ-ийн барилгын их засвар” ЭМЯ-ны /20250101004/01/01 тоот урилгын дугаартай тендер шалгаруулалт 2025 оны 04 дүгээр сарын 31-нд явагдаж, Өсөн үржих констракшн ХХК компани шалгарсан ба барилгын ажил 2025 оны 6-р сарын 02-ны өдрөөс эхэлсэн. 2025 оны 12 сарын 01-ний байдлаар их |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | засварын ажил гэрээний дагуу 90%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.<br><br>**Гүйцэтгэл: 85%** |
| 2.1.6 | Халдвар хяналт, сэргийлэлтийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. | 30,0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний биелэлт 2024 онд 80%-тай хэрэгжүүлсэн. | – Төлөвлөсөн ажлыг 90%-иас доошгүй хэрэгжүүлж, халдварын тохиолдол, дэгдэлт бүрийн үед оновчтой хариу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | 1. 2025 онд төлөвлөгөөт ажлууд 95.7%-тай биелсэн. Халдварын тохиолдол бүрийг өдөр тутмын тандалтаар бүртгэн үнэлж, мэс заслын дараах халдвар, шээлгүүртэй холбоотой халдвар, зохиомол амьсгалын аппараттай холбоотой халдвар зэрэг илэрсэн тохиолдол бүрт тохирсон арга хэмжээ авч, шаардлагатай үед дэгдэлтийн үеийн нэмэлт арга хэмжээг шуурхай хэрэгжүүлсэн. Халдварт өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдлуудад ХӨСҮТ-тэй хамтран ажиллаж, тусгаарлалтын дэглэм, эрсдэлийн үнэлгээг бүрэн хангаж ажилласнаар дэгдэлт үүсэхээс сэргийлсэн.<br>2. 2025 онд нийт 20 халдварын болон өртөлтийн тохиолдлыг бүртгэн дүн шинжилгээ хийж, нийт 53 зөрчилд зөвлөмж, дүгнэлт гарган арилгуулан ажиллав.<br><br>**Нийт бүртгэгдсэн 20 тохиолдол:**<br>1. Эмнэлгийн тусламжийн зөрчилтэй нэг тохиолдол – 1 *(Тайлангийн 3.1)* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2. ОУЭМД-ээр мэдээлэгдэх халдварт өвчин – 2 (*Тайлангийн 4.4*)<br>*3.* Төвийн венийн гуурсны халдвар – 1 *(Тайлангийн 3.2)*<br>4. Зүүнд хатгуулсан өртөлт – 16 *(Тайлангийн 2.4)*<br>**2025 онд нийт 53 зөвлөмж, дүгнэлт өгч, хэрэгжилтийг үнэлж ажилласан:**<br>1. Тасаг нэгжийн цэвэрлэгээ<br>• Илэрсэн зөрчил: 15 удаа, бүгдэд нь зөвлөмж өгч арилгуулсан *(Тайлангийн 1.2)*<br>2. Төвлөрсөн ариутгалын тасаг<br>• Илэрсэн зөрчил: 8 удаа, бүгдэд нь зөвлөмж өгсөн *(Тайлангийн 1.2)*<br>3. Нэгдсэн угаалгын тасаг<br>• Зөрчил: 2 удаа, зөвлөмж өгсөн *(Тайлангийн 1.2)*<br>4. Хоол үйлдвэрлэлийн хэсэг<br>• Зөрчил: 15 удаа, тус бүрд нь зөвлөмж өгсөн *(Тайлангийн 1.2)*<br>5. Эмнэлгийн халдвартай хог хаягдал<br>• Зөрчил: 13 удаа, бүгдэд нь зөвлөмж өгч арилгуулсан *(Тайлангийн 1.2)*<br><br>***Хавсралт 2: Халдвар хяналт, сэргийлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан.*** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Гүйцэтгэл: 95.7%** |
| **2.2. Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний чанар хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |
| 2.2.1 | Хавдрын сэргээн засах чиглэлээр 2 төрлийн эмчилгээний удирдамж батлуулж, хэрэгжүүлнэ. | – | – Батлуулсан удирдамжийн тоо<br>– Удирдамжийн дагуу хавдрын сэргээн засах эмчилгээнд хамрагдсан хүний тоо | – “Эрчимт эмчилгээний үеийн хөдөлгөөн засал эмчилгээ”, “Хөхний хавдрын сэргээн засах эмчилгээ”-ний 2 удирдамжийг боловсруулж, батлуулсан.<br>– Удирдамжийн дагуу сэргээн засах эмчилгээнд нийт 627 үйлчлүүлэгчийг хамруулсан. | – “Элэг шилжүүлэн суулгасны дараах” болон “Хавдрын мэс заслын өмнөх бэлтгэл” үеийн сэргээн засах эмчилгээний 2 удирдамж боловсруулж, Эмнэлзүйн хороогоор батлуулсан байна.<br>– Удирдамжийн дагуу сэргээн засах эмчилгээнд нийт 20 үйлчлүүлэгчийг хамруулсан байна. | III-IV улирал | “Элэг шилжүүлэн суулгасны дараах” болон “Хавдрын мэс заслын өмнөх бэлтгэл” үеийн сэргээн засах эмчилгээний 2 удирдамжийг боловсруулж, Эмнэлзүйн хорооны хурлаар хэлэлцүүлж баталсан. Удирдамжийн дагуу мэс засалд орсон 56 хүн сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 2.2.2 | Хавдрын мэс заслын өмнөх бэлтгэл сэдвээр ард иргэдэд боловсрол олгох сургалт зохион байгуулна. | – | – Хийгдсэн сургалтын тоо<br>– Сургалтанд хамрагдсан хүний тоо | – Батлагдсан хөтөлбөр байхгүй | – Улирал бүр зохион байгуулах<br>– Жилд 4 удаагийн | | ХСҮТ-ийн клиник сэтгэл зүйч, хоол зүйч, халдвар судлаач, сэргээн засах их эмч, хөдөлгөөн засалчаас бүрдсэн олон мэргэжлийн баг үйлчлүүлэгч нарт эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор дараах 5 сэдвээр |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалт хйисэн байх | | сургалтуудыг зохион байгууллаа: Үүнд:<br>1. 2025 оны 03 дугаар сарын 15-нд “Хавдрын мэс заслын өмнөх бэлтгэл”, “Амьсгалын хүндрэлээс сэргийлэх нь”.<br>2. 2025 оны 06 дугаар сарын 18-нд “Айдас түгшүүрийг хэрхэн давах”.<br>3. 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр “Мэс заслын дараах халдвараас урьдчилан сэргийлэх”.<br>4. 2025 оны 10 дугаар сарын 15-нд “Булчингийн массаа хэрхэн хадгалах вэ?<br>Дээрх сургалтад бамбай булчирхай-20, улаан хоолой, ходоод-56, элэг шилжүүлэн суулгах мэс засал-33/донорын хамт/, хөхний төв-6 болон ангиографийн эмчилгээнд орох 6 нийт 125 хэвтэн эмчлүүлэгч хамрагдсан. Сургалтаар мэс засалд өөрийгөө хэрхэн бэлдэх, мэс засалд бэлдсэнээр гарч болзошгүй хүндрэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдлэг эзэмшсэн. Мөн “Мэс заслын өмнөх бэлтгэл” гарын авлагыг боловсруулж, иргэдэд түгээсэн.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 2.2.3 | **<u>БСТ-4.2.3</u>**<br>MRI аппаратыг суурилуулж, хавдрын | 1500.0 | – Төхөөрөмж суурилуулалты | – MRI аппаратын тендер | – Тоног төхөөрөмжийг суурилуулж | III-IY улирал | Siemens Mammomat revelation-mammography apparat, Siemens samatom go.Top 128 slice-CT, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оношилгоонд ашиглана. | | н ажлын тайлан<br>– MRI оношилгоонд хамрагдсан хүний тоо | зарлагдаж, нийлүүлэгч сонгогдсон. | ашиглаж эхэлсэн байна.<br>– MRI оношилгоонд хамрагдсан хүний тоо-100-аас цөөнгүй байна. | | Siemens MAGNETOM ALTEA 1.5T-MRI аппарат суурилагдаж, оношилгоонд ашигалахад бэлэн болсо. 12 дугаар туршилтын зураг авалт хийгдэж байна.<br><br>**Гүйцэтгэл: 90%** |
| 2.2.4 | Хавдрын тусламж үйлчилгээний хүлээгдлийг бууруулах зорилгоор "Цахимаар бүртгэх, мэдээлэх журам"-ыг батлуулан хэрэгжүүлнэ. | – | – Батлагдсан журмын тоо<br>– Журмын хэрэгжилтийн хувь<br>– Эмнэлэгт хэвтэлтийн хүлээгдлийн буурсан хоног | – ЭМС-ын 2012 оны А/427 дугаар тушаалыг мөрдөж ажиллаж байна.<br>– Хэвтэн эмчлүүлэх хүлээгдлийн хоног дунджаар 8 байна. | – Ерөнхий захирлын тушаалаар журам батлагдсан байна.<br>– Журмын хэрэгжилт 80% ба түүнээс дээш<br>– Хэвтэн эмчлүүлэх хүлээгдэл дунджаар 8-аас дээшгүй хоног байна. | I улирал | 1. ХСҮТ-ийн "Тусламж үйлчилгээний хүлээгдлийг цахимаар бүртгэх, мэдээлэх журам"-ын төслийг боловсруулан захирлын зөвлөл, захиргааны зөвлөлийн гишүүдээс санал авч нэгтгэсэн.<br>2. Журмын төсөлд амбулатори, оношилгоо шинжилгээ, хэвтэлтийн хүлээгдлийг бүрэн цахимжуулах зохицуулалтыг хийж эмнэлгийн цахим программын хөгжүүлэлт хийж байна.<br>3. 2025 онтой харьцуулахад амбулаторийн хүлээгдэл 7.4 хоног, оношилгоо шинжилгээний хүлээгдэл 16 хоног, хэвтэнгийн хүлээгдэл 4.9 хоног болж эмнэлгийн тусламж үйлчилгээний нийт хүлээгдэл 6.7%-иар буурсан байна.<br><br>**Гүйцэтгэл: 80%** |
| **2.3 Хавдрын мэс засал эмчилгээний чанар хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |
| 2.3.1 | Робот мэс заслын үйлдлийн удирдамжийг | – | – Батлагдсан эмнэлзүйн | – Удирдамжийг | – Эмнэлзүйн хороогоор | III улирал | 1. ХСҮТ-д Робот технологийг мэс засал эмчилгээнд ашиглаж эхлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинээр боловсруулан батлуулж, эмч, сувилагч нарыг чадавхижуулсан байна. | | удирдамжийн тоо<br>– Сургалтад хамрагдсан эмч, сувилагчийн тоо | боловсруулж байна.<br>– Робот мэс заслын сургалтын тоног төхөөрөмж суурилагдсан. | хэлэлцүүлж, удирдамж батлагдсан байна.<br>– Мэс заслын эмч, сувилагч нарын 80-аас доошгүй хувь нь сургалтад хамрагдсан байна. | | төслийн хүрээнд 2025 онд ХСҮТ-д Робот мэс заслын сургалтын консол төхөөрөмж дээр Роботын сургалтын хөтөлбөрийг эмнэлзүйн хороогоор батлуулсан.<br>2. 7 хоног бүр ажлын өдрүүдэд мэс заслын тасгуудыг дадлага хийх тогтмол хуваарийг гаргаж, дадлагажуулах сургалтад хамруулж байна. Нийт мэс заслын эмч, сувилагч нарын 80% нь сургалтад хамаргадсан.<br>3. 2025 оны 11 сард ХСҮТ-ийн мэс заслын эмч, сувилагч, техникч нараас бүрдсэн 8 хүний бүрэлдэхүүнтэй баг БНСУ-д REVO-i компанийн Робот мэс засал ашиглалтын сургалтад хамрагдаж байна.<br><br>**Гүйцэтгэл- 100%** |
| 2.3.2 | Толгой хүзүүний нөхөн сэргээх мэс засалд 3 хэмжээст төлөвлөлт бүхий дижитал технологийг нэвтрүүлнэ. | 45,9 | – Сургалтанд хамрагдсан эмч, сувилагчийн тоо<br>– Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн тоо<br>– Нэвтрүүлсэн шинэ технологийн тоо | Толгой хүзүүний нөхөн сэргээх мэс засалд уг технологи нэвтрээгүй байсан. | – АНУ-ын Langone Health Эмнэлэгт толгой хүзүүний нөхөн сэргээх мэс заслын багийг сургаж чадавхижуулсан байна.<br>– 3 хэмжээст принтер, программ хангамж, цутгаж хэвлэх | I-IV улирал | 1. Толгой хүзүү, нөхөн сэргээх мэс заслын тасгийн 2 эмч, Хагалгаа мэдээгүйжүүлгийн нэгдсэн тасгийн 2 сувилагчаас бүрдсэн баг АНУ-ын Langone Health эмнэлэгт 2025 оны 2 сарын 10-ны өдрөөс 2025 оны 03 сарын 10-ны өдөр хүртэл 1 сарын хугацаанд толгой хүзүүний байрлалын хавдрын өргөтгөсөн мэс заслын дараах 3 хэмжээст төлөвлөлт бүхий нөхөн сэргээх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | материалаар хангагдсан байна.<br>– Шинэ технологиор 5-аас цөөнгүй толгой хүзүүний согогт нөхөн сэргээх мэс заслыг амжилттай хийсэн байна. | | мэс заслын арга технологид суралцсан.<br>2. Шинэ технологийг нэвтрүүлэх шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа хийгдсэн. 3 хэмжээст принтер, программ хангамж, цутгаж хэвлэх материалаар одоогоор хангагдаагүй байна.<br>3. Толгой хүзүүний хавдрын тайралтын дараах хатуу эдийн дефектийг 3D төлөвлөлт ашиглан тахилзуур ясны чөлөөт далбангаар нөхөн сэргээсэн 3 мэс засал хийсэн. Гавал тархины ясны дефектийг 3D төлөвлөгт ашиглан титан ялтасаар нөхөн сэргээсэн 1 мэс засал, шинэ технологи ашиглан нийт 4 мэс засал хийгдсэн.<br><br>**Гүйцэтгэл- 80%** |
| 2.3.3 | 3D дурангийн мэс заслыг нутагшуулна. | 418,0 | 3D дурангийн аргаар хийсэн мэс заслын тоо | 2024 онд Olympus 3D дурангийн багаж хэрэгслийг худалдан авч, элэг цөсний зам, нойр булчирхайн байрлалын хавдрын мэс заслын эмчилгээнд | – 3D дурангийн аргаар амжилттай хийсэн мэс заслын тоо-50 | I-IV улирал | 2025 онд 3D дурангийн аргаар элэг тайрах 30 мэс засал, нойр булчирхай, дэлүү тайрах 8 мэс засал, бөөр бүтнээр болон хэсэгчлэн тайрах 12, **нийт 50 мэс засал** хийгдсэн байна. Нийт дурангийн аргаар хийгдсэн мэс заслын 37%-д 3D технологи ашигласан байна.<br><br>**Гүйцэтгэл- 100%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ашиглаж эхэлсэн. | | | |
| 2.3.4 | Амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслын үед дурангийн мэс заслын аргаар донорын баруун элгийг тайрах технологийг нэвтрүүлнэ. | 41,8 | – Дурангийн мэс заслын тоо | БНСУ-ын Сөүлийн Их Сургуулийн эмнэлгийн хамтын ажиллагааны хүрээнд сургалт хийгдэж байна. | – 5-аас цөөнгүй дурангийн мэс заслыг амжилттай хийсэн байна. | I-IV улирал | Эмч мэргэжилтнийг ажлын байранд чадавхижуулах зорилгоор ХСҮТ нь БНСУ-ын SNUH эмнэлэгтэй хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зуралцаж, гэрээ байгуулан, цаашдын хамтын ажиллагаа эхэлсэн. Энэ хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд БНСУ-ын SNUH эмнэлэгийн профессор Kwang Woong Lee-гээр ахлуулсан мэс заслын баг ХСҮТ-ийн Элэг цөс нойр булчирхайн мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгах төвд хүрэлцэн ирж, ажлын байрны дагалдан сургалт зохион байгуулж, Монгол улсад анх удаа элэгний донорын баруун элэг тайрах мэс заслын хэвлийн дурангийн аргаар хийсэн. Төлөвлөгөөний дагуу 2025 оны 08 дугаар сарын 14 болон 15-нд багийн хамт ирж ажлын байрны сургалт, хэвлийн дурангийн аргаар элэгний донорын баруун элэг тайрах мэс засал амжилттай хийж гүйцэтгэсэн.<br>Амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслын үед дурангийн мэс заслын аргаар донорын баруун элгийг тайрах 4 мэс заслыг амжилттай хийсэн.<br><br>**Гүйцэтгэл- 100%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.5 | Амьд болон амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана. | 100,0 | – Сургаж бэлтгэсэн эмч, мэргэжилтний тоо<br>– Ханган нийлүүлсэн тоног, төхөөрөмжийн тоо | Бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийгээгүй байна. | – Бөөр шилжүүлэн суулгах мэс заслын 1 баг сургагдсан байна.<br>– Бөөр шилжүүлэн суулгах мэс заслын 1 иж бүрдэл багаж, төхөөрөмжөөр хангасан байна. | I-IV улирал | УНТЭ болон ХСҮТ-ийн хамтын ажиллагааны хүрээнд ХСҮТ-ийн Элэг цөс нойр булчирхайн мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгах төв нь УНТЭ-ийн Уролог-Андрологийн тасгийн Бөөр шилжүүлэн суулгах багтай хамтран ХСҮТ-д амьд донороос бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг 2025 оны 10 дугаар сарын 16-нд анх удаа амжилттай хийсэн. Одоогоор амьд донороос бөөр шилжүүлэн суулгах 2 мэс засал амжилттай хийгдээд байна.<br>2025 оны 04 дүгээр сараас 2025 оны 10 сар хүртэл УНТЭ-ийн Уролог-Андрологийн төвд Урологийн мэс засал судлалаар 2 эмч, УНТЭ-ийн Эрхтэн шилжүүлэн суулгах төвд бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний нефрологи судлалаар 1 эмч суралцаж төгссөн ба одоогоор ХСҮТ-д Бөөр шилжүүлэн суулгах багт 3 мэс засалч, 1 нефрологич эмчийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Бөөр шилжүүлэн суулгах 1 иж бүрдэл багажаар хангасан.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 2.3.6 | Элэг шилжүүлэн суулгах мэс заслын үеийн хүндрэл болох элэгний ховхролыг оношлох олон улсын практикт нийцсэн | - | – Элэгний ховхрол мэс заслын хүндрэлийг оношлох | Одоо гематоксилин эозины арга хэрэглэж байна Элэг ховхрох хүндрэл жилд | – Алгоритмийг Эмнэлзүйн хороогоор батлуулсан байна. | I-IV улирал | Элэг шилжүүлэн суулгах мэс заслын үеийн эмгэг судлалын шинжилгээг үнэлэх дараах 4 төрлийн алгоритмийг боловсруулж, Эмгэг судлалын салбар зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | алгоритм батлуулж мөрдөнө. | | батлагдсан алгоритм<br>– Элэг ховхрох хүндрэл буурсан хувь | дунджаар 10-20% бүртгэгддэг. | – Шинэ алгоритмыг хэрэгжүүлснээр уг хүндрэл өмнөх оныхоос 10%-иас доошгүй буурсан байна. | | ХСҮТ-ийн Эмнэлзүйн хорооны хурлаар хэлэлцэж зөвшөөрөгдсөн.<br>Үүнд:<br>1. Донорын элэгний эмгэг судлалын оношилгоо<br>2. Суулгац элэгний эмгэг судлалын оношилгоо<br>3. Суулгацын судасны хүндрэлийн эмгэг судлалын оношилгоо<br>4. Суулгацын дараах халдварууд<br><br>Элэг шилжүүлэн суулгах мэс заслын дараах элэг ховрох хүндрэлийг дээрх батлагдсан алгоритмын дагуу оношилж эхэлсэн бөгөөд 2025 онд 2 тохиолдлыг оношилсон.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 2.3.7 | Хөхний мэс засал болон туяа эмчилгээний дараах дээд мөчдийн хаван, лимфийн зогсонгишилийг оношилж, эмчлэх шинэ аргыг нэвтрүүлнэ. | - | – Лимфийн баг байгуулан ажиллана.<br>– Лимфийн зогсонгишилийг ICG ашиглан оношлоно<br>– Эмчилгээнд хамрагдсан хүний тоо | Үгүй | – Лимфийн багтай болсон байна.<br>– 5-с цөөнгүй үйлчлүүлэгчийг эмчилгээнд хамруулсан байна. | I-IV улирал | 1. Хөхний төв нь толгой хүзүү нөхөн сэргээх мэс заслын тасаг болон сэргээн засах тасагтай хамтран дээд мөчдийн хаван, лимфийн зогсонгишилийг оношилж, эмчлэх зорилгоор лимфийн багийг шинээр байгуулсан.<br>2. Сэргээн засах эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгч нарт Lymphedema complex decongestive therapy 10 хоногоор 6 сар эмчилгээ хийсэн. Нийт хамрагдсан үйлчлүүлэгчдийн 4-т нь лимфийн хаван багасаж, хэмжилтээр үр дүн сайн гарсан бол 1 эмчлүүлэгч үр дүн гараагүй тул Лимфийн зогсонгишилийг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ICG ашиглан эмчлэх аргыг сонгосон.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| **2.4 Хорт хавдрын туяа, хими эмчилгээ, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 2.4.1 | Дархлаа, бай болон гормон эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | – | – Батлагдсан эмнэлзүйн заавар<br>– Эмчилгээнд шинээр нэвтэрсэн эмчилгээний нэр, төрөл | Одоо хэргэлэж байгаа эмчилгээний төрөл, тоо: Дархлаа эмчилгээ – 1, Бай эмчилгээ- 13, Даавар эмчилгээ- 4 | – Эмчилгээнд шинээр нэвтэрсэн эмийн эмчилгээний зааврыг Эмнэлзүйн хороогоор батлуулсан байна.<br>– Дархлаа, бай эмчилгээний 3-аас цөөнгүй төрөл нэмэгдсэн байна. | I-IV улирал | Дархлаа, бай болон гормон эмчилгээний зааврыг боловсруулан Эмнэлзүйн хорооны хурлаар хэлэлцүүлэхээр илгээсэн байна.<br>2025 онд дараах 6 төрлийн бай эмийг хавдрын эмчилгээнд нэвтрүүллээ. Үүнд:<br>1. Osimertinib<br>2. Erlotinib<br>3. Palbocyclib<br>4. Phesgo<br>5. Trastuzumab emtansine<br>6. Alectinib<br>Дээрх шинэ бай эмчилгээнд нийт 30-40 хүн хамрагдсан ба эмчилгээний гаж нөлөө, хүндрэл бүртгэгдээгүй.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 2.4.2 | ОУ-ын туяа эмчилгээний чанарын баталгааг хангах аудитын QUATRO аргачлалаар тасагт дотоодын аудитыг хийнэ. | - | – QUATRO аудит хийсэн үнэлгээ хийсэн тоо<br>– Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | ОУАЭА-ийн төслийн хүрээнд 5 эмч, мэргэжилтнийг туяа эмчилгээний чанарын баталгааны аудит хийх гадаад сургалтанд хамруулсан. | – QUATRO аудитын хяналтын хуудсын дагуу шалгаж, 1 удаагийн үнэлгээ хийсэн байна.<br>– Үнэлгээнээс гарсан зөвлөмжийг 90% | I-IV улирал | Дотоод QUATRO аудитын хяналтын хуудасны боловсруулалт 100% хийгдсэн.<br>Дотоод QUATRO аудит хийж, үр дүнг гарган танилцуулж, сайжруулах саналыг 2026 оны тасгийн төлөвлөгөөнд тусган ажиллахаар төлөвлөлж байна.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжүүлсэн байна. | | |
| 2.4.3 | Аймаг дүүргийн хавдрын болон хөнгөвчлөхийн эмч, сувилагч нарыг чадавхижуулах цахим сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулна. | - | – Батлагдсан сургалтын хөтөлбөр<br>– Хийгдсэн сургалтын тоо<br>– Сургалтанд хамрагдсан аймаг, дүүргийн эмч нарын тоо | 2024 онд хийгдээгүй. | – Батлагдсан төлөвлөгөөний дагуу сар бүр сургалт зохион байгуулагдсан байна.<br>– Сургалтад давхардсан тоогоор 300-аас цөөнгүй эмч, сувилагч хамрагдсан байна. | I-IV улирал | Зайн сургалт, зөвлөгөөний журам боловсруулан ХСҮТ-ийн Ерөнхий захирлаар батлуулсан. Уг журмын дауу цахим хичээлийн хуваарь сэдэв, сургалт удирдах багшийг томилсон. Хуваарийн дагуу сар бүрийн 3 дах долоо хоногийн Мягмар гарагт Хими эмчилгээ, Лхагва гарагт хөнгөвчлөх эмчилгээний сургалт зохион байгуулсан.<br>Нийт 22 удаагийн сургалт зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн 300 гаруй хавдрын эмч, сум, өрхийн эмч, сувилагч нар хамрагдсан.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| **2.5 Цахим эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, хөгжүүлэх** | | | | | | | |
| 2.5.1 | Байгууллагын веб хуудсыг шинэчилнэ. | 4,0 | Байгууллагын шинэчилсэн веб хуудас | Одоо ашиглаж байгаа веб хуудас загвар хуучирсан, удаан ажилладаг сул талтай. | Байгууллагын веб хуудас шинэчлэгдсэн байна. | I-II улирал | Байгууллагын веб хуудсыг шинэчлэх ажлын хүрээнд төвийн шинэ веб хуудсыг үндэсний дата төв дээр байршуулж тохиргоо, цэс үүсгэж хөгжүүлэлт хийсэн.<br><br>https://eng.cancer-center.gov.mn/<br><br>**Гүйцэтгэл: 95%** |
| 2.5.2 | Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хяналт удирдлагын нэгдсэн системийг бий болгоно. | 10,0 | – Хяналт удирдлагын нэгдсэн систем<br>– Ажилтан бүрт үүсгэсэн нэвтрэх эрхийн тоо | Байгууллагын ажилчдын хяналт удирдлагын нэгдсэн систем байхгүй. | – Хяналт удирдлагын нэгдсэн систем бүрдсэн байна.<br>– Байгууллагын бүх ажилтанд системд нэвтрэх эрх | I-II улирал | 1. Төвийн ерөнхий захирлын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/25 дугаар тушаалаар “Мэдээллийн аюулгүй байдлын ерөнхий журам” батлуулан үйл ажиллагаанд дагаж мөрдөж байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | олгогдсон байна. | | 2. Сүлжээний галт хана төхөөрөмж суурилуулж халдлага илрүүлэх аюулгүй байдлын дүрмүүдийг тохируулсан.<br>3. Төвийн компьютеруудад үе шаттайгаар албан ёсны эрхтэй вирусийн эсрэг програм хангамж суурилуулж байна. 2025 онд нийт компьютерийн 45%-д суурилуулсан.<br>4. “Хяналт удирдлагын нэгдсэн систем үүсгэнэ” ажлын хүрээнд Active directory, domain серверийн тохиргоог бүрэн хийж, нийт 481 ажилтны эрх үүсгэж нэгдсэн удирдлагын орчин бүрдүүлсэн.<br>5. Компьютеруудыг domain серверт холбох ажлыг 2025 оны 12 дугаар сард багтаан дуусгана.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| **ЗОРИЛТ 3. СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ ЭРХЛЭХ** | | | | | | | |
| **3.1 Хорт хавдрын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, нотолгоонд суурилсан мэдээ, мэдээллээр хангах** | | | | | | | |
| 3.1.1 | “Зонхилон тохиолдох хавдрын эмгэг судлал” мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлнэ. | – | – Батлагдсан сургалтын хөтөлбөр<br>– Сургалтад хамрагдсан эмчийн тоо | Сургалтын хөтөлбөр байхгүй | – Батлагдсан сургалтын хөтөлбөр-1<br>– Сургалтад хамруулсан эмч, мэргэжилтний тоо - 5 | I-IV улирал | “Хорт хавдрын эмгэг судлал” мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг Нийгмийн эрүүл мэнд, сургалтын алба, эмгэг судлалын тасагтай хамтран боловсруулсан. Хөтөлбөрийг батлуулахаар ЭМХТ-д илгээсэн.<br><br>**Гүйцэтгэл: 90%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.2 | <u>БСТ-6.1.2</u><br>Хавдрын сувилахуй судлал эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна. | 5.0 | – Хуралд оролцогчийн тоо<br>– Хуралд хэлэлцүүлсэн бүтээлийн тоо | Хавдрын тулгамдсан асуудал-2024" эрдэм шинжилгээний хурлын салбар хуралдаанаар зохион байгуулж, 120 гаруй сувилагч оролцсон. | – Хуралд оролцогчийн тоо -118<br>– Хуралд хэлэлцүүлсэн бүтээлийн тоо аман илгэл-13, ханын илтгэл-3 | III-IV улирал д | Хавдар судлалын тулгамдсан асуудал-2025 эрдэм шинжилгээний хурлын хүрээнд Сувилахуйн албатай хамтран "Хавдрын сувилахуй" сэдэвт ЭШОПБ хурлыг зохион байгуулж, 100 гаруй сувилагч, мэргэжилтэнүүд оролцлоо.<br>Хурлын хүрээнд 10 илтгэлийг амаар, 6 илтгэлийг ханын илтгэл хэлбэрээр хэлэлцүүлж, шилдэг 4 илтгэлийг шалгаруулсан. Хуралд **"Хавдрын сувилахуй-2025"** эрдмийн хуралд 13 илтгэл хэлэлцүүлснээс дараах илтгэлүүд шалгарлаа.<br>**Аман илтгэлийн төрөлд:**<br>**1-р байрт:** Л.Данзанням "Сувилагчдын ажлын бүтээмж түүнд нөлөөлөх хүчин зүйлс", **2-р байрт:** П.Долгорсүрэн "Хүний хөхөнцөр вирусийн генотип тодорхойлсон судалгаа", **3-р байрт:** Б.Соёлзул "Брайданы болон Карновский үнэлгээний хамаарлыг судалсан дүн",<br>**Ханын илтгэлийн төрөлд:** А.Анударын "Элэгний хорт хавдартай өвчтөнүүдэд AFP болон PIVKⅡ-ийн мэдрэг чанар тодорхойлсон дүн" зэрэг илтгэлүүд шалгарсан.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 3.1.3 | **<u>БСТ-6.1.2</u>**<br>"Хавдар судлалын тулгамдсан асуудал- | 60.0 | – Ерөнхий захирлын тушаал | **"**Хавдар судлалын тулгамдсан | – Тушаал-1<br>– Оролцогчдын тоо-300 | III-IV улирал | ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/30 дугаар тушаалаар хурал зохион |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2025” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна. | | – Оролцогчдын тоо<br>– Салбар хуралдааны тоо<br>– Хэлэлцүүлсэн илтгэлийн тоо<br>– Хэвлүүлсэн сэтгүүл | асуудал-2024” эрдэм шинжилгээний хурлыг үндсэн болон 5 салбар хуралдаанаар зохион байгуулж, нийт 400 гаруй эмч мэргэжилтнүүд хамрагдсан. | – Салбар хуралдааны тоо-5<br>– Хэлэлцүүлсэн илтгэлийн тоо-50-аас цөөнгүй<br>– Хавдар судлал сэтгүүлийг 300 ширхэг хэвлүүлж түгээсэн байна. | | байгуулах ажлын удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, бэлтгэл ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулан ажилласан. Хавдар судлалын эрдэм шинжилгээний хурлыг үндсэн болон салбар хуралдаанаар зохион байгууллаа. Үүнд:<br><br>Үндсэн хуралдаан: ***“Хавдар судлалын тулгамдсан асуудал-2025***” эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр<br><br>Салбар хуралдааныг ХСҮТ-ийн Нийгмийн эрүүл мэнд, мэдээллийн төвд зохион байгууллаа.<br>● **“Элэг ба түрүү булчирхайн хорт хавдрын үеийн туяа эмчилгээ”** сургалтыг 2025.09.17-нд<br>● ***“Хавдрын сувилахуй судлал”*** эрдмийн хурлыг 2025.10.10-нд<br>● ***“Системийн хими ба дархлаа эмчилгээний чиг хандлага”*** сэдэвт сургалтыг 2025.10.16-нд<br>● ***“Хавдрын молекул генетик болон эмгэг судлалын оношилгоо”*** сэдэвт хурлыг 2025.10.16-нд<br>● ***“Эмнэл зүйн ховор тохиолдлын хэлэлцүүлэг”***-ийг 2025.10.16-нд<br><br>Хурлыг Эрүүл мэндийн сайд, АУ-ны доктор Ж.Чинбүрэн, ХСҮТ-ийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ерөнхий захирал АУ-ны доктор, профессор Ц.Батболд нар нээж, ОХУ-ын болон Сингапур, Япон улсаас ирсэн зочин профессорууд уригдан оролцож, илтгэл тавьлаа. Энэ удаагийн хуралд 460 гаруй эмч, мэргэжилтэн хамрагдлаа. Хурлын үеэр хавдар судлалын салбарт хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээлүүд болон эмнэлзүйн ховор тохиолдлыг хэлэлцүүлсэн. Мөн оношилгоо, эмчилгээнд нэвтрүүлсэн шинэ технологийн талаар мэдээлэл, туршлагаа хуваалцлаа.<br><br>Хуралдааны үеэр нийт 88 аман илтгэл, 16 ханын илтгэлийг хэлэлцүүлж, шилдэг 13 илтгэл (Аман-9, Ханын-4)-ийг шалгаруулж, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Мөн энэ үеэр орон нутгийн шилдэг эмч, хамт олныг шалгаруулж, урамшууллаа. Хуралд ирүүлсэн судалгааны бүтээлийг эмхэтгэн Хавдар судлал сэтгүүлийг 300 ширхэг хэвлүүлэн түгээсэн.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 3.1.4 | **<u>БСТ-6.1.1</u>**<br>Эмнэлзүйн туршилт судалгаа (clinic trial) хийнэ. | 350,0 | – Судалгааны ажлын гүйцэтгэлийн хувь<br>– Судалгааны тайлан | Архаг Д гепатитын эмчилгээнд Гепалатид эмийг хэрэглэх олон төвт санамсаргүй | – Батлагдсан арга аргачлалын дагуу Олон төвт эмнэлзүйн туршилт судалгааг үргэлжлүүлэн, | I-IV улирал | “Архаг D гепатиттай оролцогчдод тарилгаар хийх гепалатидын зэрэгцээ бүлэгт, санамсаргүй түүвэрлэлттэй, нууцлалгүй эмнэлзүйн туршилт судалгаа” (L47-HD-MN)-г ХӨСҮТ, хамтран гүйцэтгэж байна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | түүвэрлэлттэй, давхар нууцлалт, плацебо-хяналт бүхий IIa шатны эмнэлзүйн судалгааны ажлын арга аргачлал батлагдаж, судалгааны ажил амжилттай хэрэгжиж байна. | гүйцэтгэлийн хувь -80%<br>– Судалгааны явцын болон эцсийн тайланг Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | | ХСҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн 2024 оны 07 сарын 03-ны өдрийн (No:07), ЭМЯ-ны дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2024 оны 07 сарын 09-ний (No:24/065) тоот тогтоолоор судалгаа эхлүүлэх зөвшөөрлийг тус тус авсан.<br>**Судалгааг** 2024 оны 11 дүгээр сарын 28-наас 2025 оны 04 дүгээр сарын 12 хүртэл хугацаанд таниулсан зөвшөөрлийн хуудаст гарын үсэг зурсан нийт 200 оролцогчийг илрүүлэг үзлэгт хамруулснаас 90 оролцогчид судалгаанд орох шалгуурыг хангасан байна.<br>**Судалгааны 3 бүлгийн санамсаргүй хуваарилалт:** Эмчилгээний 2.1 гр эмийн бүлэг (15) ба эмчилгээний 4.2 гр эмийн бүлэг (11), эмчилгээний хойшлуулсан бүлэг (12)-т 2025 оны 01 сарын 10-наас эмчилгээг эхлүүлж, идэвхтэй хянаж байна. Эмчилгээний бүлэгт гепалатид тарилга ба энтекавир эмийг, харин эмчилгээний хойшлуулсан бүлэгт зөвхөн B вирусын энтекавир эмийг өгч байна.<br>**Эмийн үр дүн, сөрөг нөлөө:** Эмчилгээний дунд үед HDVRNA-ийн биомаркеруудыг үр дүнтэй бууруулах боломжтой байна. Эмчилгээний явцад ноцтой сөрөг нөлөө 4 тохиодол бүртгэгдсэн. Судалгааны явцын тайланг Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ЭМЯ-ны Ёс зүйн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | салбар хорооны хурлаар хэлэлцүүлж байна.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| **3.2 Хавдар судлалын салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх** | | | | | | | |
| 3.2.1 | **<u>БСТ-4.9.4</u>**<br>Орон нутгийн хавдрын эмч, сувилагч нарт хими эмчилгээний цахим сургалтын удирдамжийг батлуулан хэрэгжүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө. | 3.0 | – Зохион байгуулсан цахим сургалтын тоо<br>– Сургалтад хамрагдсан эмч, сувилагчийн тоо<br>– Цахим үзлэг, зөвлөгөөнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо<br>– Сэлгэн ажилласан аймгийн тоо | 2024 онд: 4 аймагт ажлын байрны сургалт зохион байгуулж, 4 эмч сэлгэн ажиллаж 80 хүнд хими эмчилгээний үзлэг хийж зөвлөгөө өгч ажилласан. | – Сар бүр 1 удаа цахим сургалт зохион байгуулсан байна.<br>– Давхардсан тоогоор 300-аас цөөнгүй эмч, сувилагч сургалтад хамрагдсан байна.<br>– Цахим эмч нарын зөвлөгөөнөөр 20-иос цөөнгүй өвчтөнд үзлэг, зөвлөгөө үзүүлсэн байна.<br>– 5 аймагт эмч сэлгэн ажилласан байна. | I-IV улирал | Зайн сургалт, зөвлөгөөний журам боловсруулан ХСҮТ-ийн Ерөнхий захирлаар батлуулсан. Уг журмын дауу цахим хичээлийн хуваарь сэдэв, сургалт удирдах багшийг томилсон. Хуваарийн дауу сар бүрийн 3 дах долоо хоногийн Мягмар гарагт Хими эмчилгээ, Лхагва гарагт хөнгөвчлөх эмчилгээний сургалт зохион байгуулсан. Нийт 22 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 300 гаруй хавдрын эмч, сум, өрхийн эмч, сувилагч нар хамрагдсан.<br><br>**Гүйцэтгэл-100%** |
| 3.2.2 | Орон нутгийн эх барих эмэгтэйчүүдийн эмч нарт зориулсан ажлын байрны гардан мэс заслын сургалт зохион байгуулна. | 10,0 | – Зохион байгуулсан сургалтын тоо<br>– Сургалтад хамрагдсан эмч, | – 2024 онд 4 аймагт ажлын байрны сургалтыг | – 4 удаагийн сургалт зохион байгуулсан байна.<br>– Сургалтад 50 эмч хамрагдаж, | I-IV улирал | 1. Монгол эмэгтэйчүүдийн хорт хавдартай тэмцэх үндэсний нийгэмлэгтэй хамтран “Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэлт ба урьдал өвчний оношилгоо, эмчилгээ” |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжилтэний тоо | зохион байгуулсан.<br>– Сургалтад 35 эмч хамрагдаж, 10 мэс заслыг хамтран хийсэн байна. | 10-аас доошгүй мэс заслыг хамтран хийсэн байна. | | багц цагийн сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Сургалтыг лекц, дадлага, гардан байдлаар явуулсан. Сургалтыг 12 сэдвээр 20 цагийн лекц, умайн хүзүүний урьдал эмгэг болон өмөнтэй 58 өвчтөн үзэж үнэлгээ өгсөн, 9 өвчтөнд умайн хүзүүг тайрах мэс засалд орж, зориулалтын материал дээр гардан мэс засал хийх байдлаар удирдан зохион байгуулсан. Сургалтанд 16 эрүүл мэндийн байгууллагын 31 эх барих, эмэгтэйчүүдийн эмч хамрагдсан байна.<br>2. Монгол эмэгтэйчүүдийн хорт хавдартай тэмцэх үндэсний нийгэмлэгтэй хамтран “Умайн хүзүүний эсийн болон ПСР-ийн шинжилгээний сорьц авах арга зүй” сэдэвт багц цагийн сургалтыг 2025 оны 03-р сарын 27-нд цахимаар зохион байгуулж, Улаанбаатар хотын 8 дүүргийн ӨЭМТ-ийн 217 эмч, бага эмч, сувилагч нар хамрагдлаа.<br>3. 2025 оны 12 дугаар сарын 02-ноос 2025 оны 05-ны өдрүүдэд ДЭМБ-тай хамтран Умайн хүзүүний хорт хавдрын кольпоскоди оношилгоо болон гогцоогоор түлэх эмчилгээний арга зүй сэдэвт сургач багш бэлтгэх олон улсын сургалт зохион байгуулж, сургалтад |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Камбож, Вьетнам, Лаос, Papua New Guinea, Филлипин, Соломон арал, Кирбати, Монгол зэрэг улсаас 40 эх барих эмэгтэйчүүдийн эмч суралцлаа.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 3.2.3 | **<u>БСТ-6.3.2</u>**<br>Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшил олгох болон мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг хуваарь, хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. | 50,0 | – Зохион байгуулсан сургалтын төрөл, тоо<br>– Батлагдсан сургалтын тойролтын хуваарийн дагуу дадлагажсан эмчийн тоо<br>– Төгсөгчийн тоо<br>– Төгсөлтийн дараах сургалтын хяналт шинжилгээн үнэлгээ (ХШҮ)- ний дүн | – Үндсэн нэг мэргэшлээр 9, төрөлжсөн 4 мэргэшлээр 24 эмч, сувилахуйн 2 мэргэшлээр 28 сувилагч, мэргэжил дээшлүүлэх 10 чиглэлээр 45 эмч, нийт 105 эмнэлгийн мэргэжилтэн суралцаж төгссөн.<br>– Тойролтын хуваарийн дагуу 200 гаруй дадлагажигч эмч нар тойролт хийсэн. | – Үндсэн (1) болон төрөлжсөн мэргэшил (6), мэргэжил дээшлүүлэх (10) чиглэлээр сургалтууд зохион байгуулсан байна.<br>– Төгсөгчийн тоо 100-аас цөөнгүй<br>– Тойролтын хуваарийн дагуу 200-аас цөөнгүй суралцагч дадлагажсан байна.<br>– ХШҮ-ний дүн өмнөх оноос буураагүй байна. | I-IV улирал | 2025 онд ХСҮТ нь төгсөлтийн дараах сургалтаар дараах мэргэжлийн чиглэлээр сургаж төгсгөсөн. Үүнд:<br>1. Хавдар судлал үндсэн мэргэжил-12 эмч<br>2. Хавдрын хими эмчилгээ судлалаар 9 эмч<br>3. Эмэгтэйчүүдийн хавдар судлал- 6 эмч<br>4. Толгой хүзүүний мэс засал-13 эмч<br>5. Хавдрын сувилахуй -17 сувилагч<br>6. Хөнгөвчлөх сувилахуй-10 сувилагч<br>7. Хавдрын мэс заслын мэргэжил дээшлүүлэх сургалтанд 25 эмч<br>8. Хавдрын ангиографи /интервеншнал радиологи/ сургалтыг 7 эмч,<br>9. Эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслаар 6 эмч,<br>10. Умайн хүзүүний эс зүй судлал 5 эмч,<br>11. Хавдрын бүртгэл судлал- 4 бага эмч,<br>12. Хавдрын хими эмчилгээний найруулга зүйн дээшлүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | – 2024 онд ХШҮ-90% | | | сургалтыг 10 эм зүйч, найруулагч<br>2025 онд нийт 124 эмч, мэргэжилтэн суралцаж төгссөн байна.<br>Тойролтын хуваарийн дагуу гэрээт байгууллагын 205 суралцагч эмч ирж суралцсан.<br>Төгсөлтийн дараах сургалтын хяналт шинжилгээний үнэлгээ (ХШҮ)- гээр 90%-ийн үнэлгээтэй үнэлэгдсэн.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| 3.2.4 | **<u>БСТ-4.9.4</u>**<br>“Ажиллан сурах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, аймаг, дүүргийн эмч мэргэжилтнүүдийг сургаж, чадавхижуулна. | 20,0 | – Эрүүл мэндийн байгууллагатай хийсэн гэрээ<br>– Зохион байгуулсан сургалтын тоо<br>– Сургалтанд хамрагдсан тоо | – Гэрээ байгуулсан аймаг - 10<br>– Сургалтанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн- 69<br>– Зохион байгуулсан сургалт-10 | – Байгуулсан гэрээний тоо- 12<br>– Сургалтанд хамрагдсан хүн – 75,<br>– Зохион байгуулсан сургалтын тоо- 10 байна. | I-IV улирал | 1. 2024-2025 онд гэрээт байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээний загварыг шинэчлэн боловсруулж, нийт 13 байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажилласан.<br>2. 2025 онд ЭМС -ын А/513 дугаар тушаалаар төвлөрлийг бууруулах ажлын хүрээнд “Ажиллан суралцах хөтөлбөр”-ийн дагуу Хавдар судлал үндсэн мэргэшлээр 2 эмч /УГТЭ, Орхон БОЭТ/, хавдрын хими эмчилгээ судлалаар Увс, Хөвсгөл, Хэнтий, Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн 4 эмч, хавдрын хөнгөвчлөх эмчилгээ судлалаар Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн, Өмнөговь, Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн 3 эмч нийт 9 эмч суралцаж төгссөн. Хавдрын мэс заслын мэргэжил дээшлүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтанд 10 эмч, хавдрын хими эмчилгээний найруулга зүйн сургалтанд 8 эм зүйч найруулагч, хавдрын сувилахуйн төрөлжсөн мэргэшлийн сургалтанд 10 сувилагч тус тус суралцаж төгссөн байна. Мөн ажлын 5 хоногоос 1 сарын хугацаатай ажлын байранд дагалдан суралцах хөтөлбөрт аймаг дүүрэг, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн 40 гаруй эм,ч мэрэгжилтэн хамрагдлаа.<br>Ажиллан суралцах хөтөлбөр"-ийн дагуу нийт 78 эмч, мэргэжилтэн суралцаж төгссөн.<br><br>**Гүйцэтгэл: 100%** |
| **ЗОРИЛТ 4. САНХҮҮГИЙН БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАЖ, ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХ** | | | | | | | |
| 4.1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ | 5,0 | – Хэрэгжилтийн тайлан | Ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн, зөв хуулийн хугацаанд мэдүүлсэн. | – Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнасан байна. | I-IV улирал д | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан ажиллалаа. Төлөвлөгөөнд тусгасан 5 зорилтын хүрээнд нийт 13 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд бүх үйл ажиллагаа 100%-ийн гүйцэтгэлтэй биелсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг дүгнэвэл:<br>1. АТГ-ын контентуудыг олон нийтийн сувгаар түгээж, иргэдэд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэв. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2. Туяа эмчилгээний хүлээгдлийг 2 сараас 2 хоног болгон бууруулав.<br>3. Хойд бүсийн оношилгоо эмчилгээний төвийг ажиллуулж хүлээгдлийг 3–4 хоног болгож багасгав.<br>4. Ёс зүйн сургагч багшаар 31 ажилтныг бэлтгэв.<br>5. Өргөдөл, гомдлын тоо буурч, үйлчилгээний чанар сайжрав.<br>6. ХАСУМ/ХАСХОМ-ын хяналт, томилгооны ил тод байдлыг ханган ажиллав.<br><br>***Хавсралт 3: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан.*** |
| 4.2 | Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 150.0 | – Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зорилгоор хэрэгжүүлсэн үйл ажиллагаа | – 2024 онд ажилтнуудын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 40 гаруй үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. | – Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажиллана.<br>– Үйл ажиллагаа бүрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн байна. | I-IV улирал | Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 3 зорилгын хүрээнд нийт 44 ажил төлөвлөн, 100% хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгээс товч дурдахад:<br>**1. Цалин урамшууллын тогтолцоог сайжруулах:**<br>• Цалин, нэмэгдэл хөлсийг нэмсэн<br>• Үр дүнгийн урамшууллыг тогтмол тооцож, олгодог<br>• Ажилтнуудад сургалт, чөлөө, зээл, виз зэрэг бүх төрлийн дэмжлэг үзүүлсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **2. Эрүүл, аюулгүй ажлын байр бүрдүүлэх**<br>• Барилгын засвар хийж орчныг сайжруулсан<br>• ХАБЭА болон аюулгүй ажиллагааны сургалтууд зохион байгуулсан<br>• Цагийн бүртгэл, ажлын цагийн зохицуулалт шинэчлэгдсэн<br>**3. Дэмжлэгт орчин бүрдүүлэх**<br>• Зээлийн нөхцөлийг сайжруулсан<br>• Сэргээн засах эмчилгээ, урлаг–соёлын арга хэмжээг зохион байгуулсан<br>• Ажилтнуудын сэтгэлзүй, нийгмийн орчныг дэмжсэн олон ажил хийсэн<br><br>***Хавсралт 4: Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан*** |
| 4.3 | ХСҮТ-ийн ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 50,0 | – Зохион байгуулсан ажлын тоо | 2024 онд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 30-н ажил зохион байгуулсан | – Үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллана. | I-IV улирал д | ХСҮТ-ийн ажилчдын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөрт үндсэн 3 зорилгын хүрээнд 24 ажил төлөвлөн 100% хэрэгжүүлсэн. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгээс товч дурдахад:<br><br>1. Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт ажилчдын 92–99% хамрагдаж, өвчлөлийн эрт илрүүлэг сайжрав. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 2. МТСА нян тээгч 26 ажилтныг бүрэн эрүүлжүүлж, халдварын эрсдэлийг бууруулсан.<br>3. Сэтгэлзүйн зөвлөгөө, стресс-түгшүүрийн судалгаа, СВСТ сургалтад олон ажилтан оролцож, сэтгэцийн эрүүл мэндийн дэмжлэг эрчимжив.<br>4. Монгол бүжгийн сургалт, ажлын байрны дасгал, спортын 5 төрөлт, hiking therapy зэрэг хөдөлгөөний хөтөлбөрүүдийг тогтмолжуулж, идэвх оролцоо нэмэгдсэн.<br>5. Ажлын байрны нөхцөл (гэрэлтүүлэг, агааржуулалт, халаалт, засвар урсгал) сайжирч, 80%-ийн гүйцэтгэлтэй засварын ажил хийгдсэн.<br>6. Шинэ ажилтны эрүүл мэндийн шинжилгээг 100% хэрэгжүүлж, В гепатитын вакцинжуулалт хамруулахад ажилчдын 87%-д дархлаа тогтоод байна.<br>7. Хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаж, 2025 онд ажлын байрны осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл бүртгэгдээгүй.<br>8. Ажилчдыг хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангасан.<br>9. Ундны усны шинжилгээг хийлгэж, эмгэг төрөгч илрээгүй, ундны усны шүүгчээс эрүүл зүйн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шинжилгээ авахад зөрчил илрээгүй.<br><br>***Хавсралт 5: Хавдар судлалын үндэсний төвийн ажилчдын эрүүл мэндийг Дэмжих дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан*** |

**ЗОРИЛТ 1:** ХОРТ ХАВДРЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ- нийт 5 арга хэмжээ, хэрэгжилтийн хувь 90%

**ЗОРИЛТ 2:** ХОРТ ХАВДРЫН ЛАВЛАГАА ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ- нийт 22 арга хэмжээ, хэрэгжилтийн хувь 95.3%

**ЗОРИЛТ 3:** СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ ЭРХЛЭХ- нийт 8 арга хэмжээ, хэрэгжилтийн хувь 98.7%

**ЗОРИЛТ 4:** САНХҮҮГИЙН БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАЖ, ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХ- нийт 3 арга хэмжээ, хэрэгжилтийн хувь 100%

НИЙТ 38 АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ 96%

**ТАЙЛАН ХЯНАСАН:**

| | |
|---|---|
| ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ | Ц.БАТБОЛД |
| ЭМНЭЛЗҮЙ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ | С.ХҮРЭЛСҮХ |
| ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ | Э.ХИШИГДОРЖ |

**ТАЙЛАН НЭГТГЭСЭН:**

| | |
|---|---|
| НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, СУРГАЛТЫН АЛБАНЫ ДАРГА | Ц.БАДАМСҮРЭН |
| ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН | Э.ӨНӨРМАА |